

Ж.ДАШДОНДОГ



ААВ

ЭЭЖ




БИ

Жамбын ДАШДОНДОГ

Адаб Эзжүс Түү

Зургийг Жамбын ЦОЛМОНБААТАР

Улаанбаатар 2007



Ж.Дашдондог
ААВ ЭЭЖ БИ

Сургуулийн өмнөх болон сургуулийн бага насныханд

Нэмж засварласан хоёрдахь хэвлэл

Зургийг Ж.Цолмонбаатар
Хавтасны зургийг Д.Сандагдорж
Хянан тохиолдуулагч Н.Энхжаргал
Хэвлэлийн эх бэлтгэсэн Д.Хишигдэлгэр



Хэвлэн нийтлэлийг Интерпресс ХХК
2007 он



Дэлхийн банктай хамтран хэрэгжүүлж буй
"Хөдөөгийн боловсролын дэмжих (READ)
төсөлт"-ийн хурээнд хавлэв.
Худалдахыг хориглоно.

ААВ ЭЭЖ БИ АМГАЛАН БОЛ АЛТАН ДЭЛХИЙ АМГАЛАН

Номын энэхэн хуудсыг ямархан гар зргүүлж байна вэ? Жижиг үү, том уу? Аль нь ч байсан яахае. Хүүхдийн бяцхан гар зргүүлж байгаа бол үе тэнгийнхний чинь уран сэтгэмжийн гайхамшигт өртөнөц хулзэж байна. Томчуудын бадриун гар зргүүлж байгаа бол та хүүхэд насныхаа баясгалант өртөнцөд зргэн очих болж дээ. Би ч гэсэн энэ номыг бутзэх гэж өгрээр дүүрэн хөл хөөрцөг болж байсан өнгөрсөн зууны жараад оны сүүлч руу буцах очихоос.

Жамбынх гэдэг айлын аяганы ширээн дээр Цолмонбаатар гэдэг жаал хүү хөр талдаа бөөрөнхий гогцоотой, дундваа дервэн шүдтэй юм зураад, "Энэ юу вэ?" гэж надаас асуув. "Сам" гээтэл "Биш, хонь" гэлээ шүү. "Тэгээл аль нь толгой, аль нь сүүл юм бэ?" гээтэл "Тээр хол бэлчиж яава хонини толгой сүүл нь хаанаа байгааг би яаж мэдэх юм бэ?" гэдэг байгаа. "Оллоо!" гэж хашгираад би дүүгээг тэвэрч үнслээ. Дүү гайхаж байна. Хүүхдийн сод ухааныг би олж харлаа.

Тэээд би тэр дор нь "Хонин сурзэ" шүүлэг бичив. Шинэ ном зохиох ажилд манай гэр бүлийнхэн эрвийх дээрэйхээрээ л оролцлоо. Урчуудын хороонд ажилладаг ава минь өнгө өнгийн будаг авчраад л, дэлгүүрт ажилладаг эзж минь дэвтэр цаас зөвгөөд л, дүү зөгсоо зайнгуй зураг зураад л, би яахае гурвалжин хөлт жижиг ширээн дээрээ шүүлэг бичээд л. Эцэст нь "Аав, Ээж, Би" гэдэг ном төрөө. Номын дэлгүүрийн лангуунд хүрэв уу, угүй юу л шуугиан тарьж эхэллээ. Хэтэрхий хийсвэр болж л гэнэ. Бага насаа дурсаж инээлдлээ л гэнэ. "Хүний хэлэх хамаагүй, хүүгийнхээ угийг дагая даа" гэж ардын дуунд гардагчлан би ч дүүгийнхээ зургийг шутэж, ямар ч гэсэн хүүхдийн дотоод сэтгэл руу нэвтрэн орж чадлаа гэж өөрийгөө баясгаж явлаа.

Тийнхүү бодсон минь ч талаар болсонгүй. Тэр тухай гадаад дотоодын судлаачид ч нээ бус удаа бичиж, миний бодлыг баталж байлаа. Орос, Украян, Туркмен, Болгар зэрэг олон оронд орчуулагдан хэвлэгдлээ. Анги намын ялгаатай гэж үздэг японд хүртэл нэрт монголч эрдэмтэд нь орчуулж хэвлүүлснийг гуч шахам жилийн дараа би узсэн. Гадаад дотоодын хүмүүс яагаад ийнхүү сонирхол болөв? Энэ номын хуудсан дээр дахин үл давтагдах ариуухан тунгалаг хүүхэд насных нь алтан өдруүд шингэж улдсэн ч байж мэдэх юм.

(Үргэлжлэл нь хавтасны ар талд)

AAB



Миний аав
Айлын
Жаалын
Ааваас өндөр

Миний аав
Хүний
Хүүхдийн
Ааваас өндөр

Аав намайг
Мөрөн дээрээ
Өргөн гаргав

Аав намайг
Өөрөөсөө
Өндөр болгов

Аавын мөрөн дээрээс
Талын бараа
Алган дээр тавьсан мэт
Илхэн байлаа

Цэцэгт тал
Цэнхэр гол
Тэртээд
Тэмээ мал
Тэгээд
Хэдэн айл

Хоолойд
Хонин сүрэг
Хойно нь
Морьтой хүн

Алсад
Ачааны тэрэг
Ард нь

Алтан тоос

Ааваас би
Асуулаа:
- Аав аа,
Аав аа?
Өөрөө яагаад ийм
Өндөр болсон юм бэ?

Аав надад
Хариуллаа:
- Алсын
Алсын барааг
Аав нь хүүдээ харуулах гэж
Өндөр болсон юм даа!



ЭЭЖ

Ээж минь
Эрээн алчууртай
Ногоон дээлтэй
Ээжийгээ
Эрээн алчууртай нь
Ногоон дээлтэй нь
Зурчихлаа, би
Будчихлаа, би

Ээж минь
Хувин дүүрэн ус
Худгаас барьдаг
Ээжийгээ
Худгаас татсан
Хувинтай устай нь
Зурчихлаа, би
Будчихлаа, би

Ээж минь
Найрсаг зантай
Наддаа хайртай
Ээжийнхээ
Найрсаг зантайг нь
Наддаа хайртайг нь
Хэрхэн зурах вэ, би?
Хэлж өгнө үү, та!



БИ

Би

Би

Би чадна
Юуны төлөө
Гартай билээ
Зурж чадна
Байнга ажилтай баруун гартаа
Зургаан хуруу зурж орхилоо
Бага ажилтай зүүн гартаа
Дөрвөн хуруу зурж орхилоо

Энэ гар
Таных ч биш
Чинийх ч биш
Минийх
Минийх!

Би
Би
Би чадна
Юуны төлөө
Хөлтэй билээ
Гүйж чадна
Хүний бага нь дэгдээрэй! гэхээр
Хөл минь аяндаа хөнгөрөөд ирдэг
Дэмжлэг тус хэрэгтэй газар луу
Дэлхийг тойрч гүймээр байдаг
Энэ хөл
Таных ч биш



Чинийх ч биш
Минийх
Минийх!



Би
Би
Би чадна
Юуны төлөө
Нүдтэй билээ
Харж чадна
Хурдан морь болгож хараад
Хусан шилбүүрийг уралдуулж чадна
Хүчит бөх болгож хараад
Хөндийн шивээг барилдуулж чадна

Энэ нүд
Таных ч биш
Чинийх ч биш
Минийх
Минийх!

Би
Би
Би чадна
Юуны төлөө
Чихтэй билээ
Сонсож чадна
Ингэ тэг! гээд үглээд байхаар
Энэхэн чих минь багасаад ирдэг
Эрт цагт гээд үлгэр эхлэхээр
Эргээд дорхноо томроод ирдэг
Энэ чих
Таных ч биш



Чинийх ч биш
Минийх
Минийх!

Би
Би
Би чадна
Юуны төлөө
Амтай билээ
Ярьж чадна
Асуултын хариуг хоёрхон үгний
Алинаар нь хэлэхээ мэдэлгүй яахав
Анд найз болох уу? За,За!
Алаг цэцэг таслах уу? Үгүй, үгүй!

Энэ ам
Таных ч биш
Чинийх ч биш
Минийх
Минийх!

Би
Би
Би чадна
Юуны төлөө
Хамартай билээ
Үнэртэж чадна
Талын тармаг өвсөн дундаас
Таанын хурц үнэрийг ялгана
Шөнийн олон үнэр дундаас
Өөрийн гэрийн утааг ялгана
Энэ хамар
Таных ч биш

Чинийх ч биш
Минийх
Минийх!

Би
Би
Би чадна
Юуны төлөө
Толгойтой билээ
Сэтгэж чадна
Бийр будгаар өөрийгөө зуртал
Биеэс толгой нь томдож орхив
Элдэв бодол багтахгүй байхад
Ингэж зурахаас өөр аргагүй


Энэ толгой
Таных ч биш
Чинийх ч биш
Минийх
Минийх!



ӨВӨӨ

Өвөө түлээнд яваад
Өдөр эргэж ирэхдээ
Хусны ур авчирч өглөө
Хулгана байна, харав уу? гэлээ
Юу гэнэ ээ?
Юун хулгана?
Хаана байна?
Харахгүй байна? гэтэл
Өвөө
Өврөөсөө
Эвхмэл хутгаа гаргаад
Эхлэж үйсийг нь
Хуулаад
Өөлөөд
Сийлээд
Хулгана болгож орхив

Хус модны бондгор урнаас
Хулгана олоод харчихыг нь бодоход
Өвеөгийн нүд муудсан гэдэгт
Үнэмших арга даанч алга даа!





ЭМЭЭ

Дэндүү халуун жин үдэд
Дээлээ дэлгэж сүүдэр босгоод
Намайг дор нь тоглуулж орхиод
Наранд өөрөө шарагдан суудаг

Миний эмээ
Ийм л эмээ!

Олны хелхөх гудамжинд гарч
Орсон цасыг шүүрдэн явдаг
Хамаг хүүхэд хальтрах вий гэж
Хавийн цасыг арилган явдаг

Миний эмээ
Түмний эмээ!

Үдээр шиг туранхай жаал хүүг
Үдшийн цэнхэр дэлгэцнээс хараад
Хэний үр юм бол доо, хөөрхий
Хэдэн бууз хүргэж өгөхсөн гэнэ

Миний эмээ
Дэлхийн эмээ!







АХ

Тонгорч бухсан эмнэгийн нуруунд
Тогтож хавчсан эрийг хараад
Харав уу, энэ чинь миний ах гээд
Хавийн жаалуудад гайхуулж хэлэх

Яа яа яа

Ямар гоё вэ?

Хэлж бараг дуусаагүй байтал
Хэрэг бишдэж ах унах нь тэр
Хөөш, энэ чиний ах уу? гээд
Хүүхдүүд элдвээр баалан хэлэх

Яа яа яа

Ямар хэцүү вэ?

Эрэмгий зоригтон болъё гэвэл
Эхлээд унаж сурдаг юм гэж
Том хүмүүс тал талаас
Тоосон шинжгүй бахархан хэлэх

Яа яа яа

Ямар сайхан бэ?



ЭГЧ



Эгчийн ажил
Эртээс эрт
Эхлэдэг
Ивэлгэдэг
Саадаг
Өрддэг
Чанадаг
Шүүдэг
Шахдаг
Бүрдэг
Арчдаг
Угаадаг
Эвхдэг
Оёдог
Нэхдэг
Томдог
Ээрдэг
Үүрдэг
Түүдэг
Зуурдаг
Элддэг
Хэрчдэг
Хайрдаг
Дайлдаг
Уншдаг

Бичдэг
Уядаг
Хашдаг
Эгчийн ажил
Ихээ орой
Дуусдаг





ДҮҮ

Хамгийн сайхан мэдээ сонслоо
Урай!

Хамт тоглох дүүтэй боллоо
Урай!

Амаржих газраас гэртээ ирлээ
Урай!

Ах нь гэсээр дүүгээ утглаа
Урай!

Хамаг тоглоомоо аваад иртэл
Харж байснаа уйлж гарлаа
Боодолтой ийм жаахан амьтан
Босож яаж ч тоглох билээ

Урам хугараад зогсож байтал
Уртын дууны аялгуу эгшиглэв
Уйлсан дүү минь инээж байна
Уянга эгшигийг ойлгож байна

Урай!

Урай!



БОРОО

Зураас
Зураас
Зуун зураас
Ташуу
Ташуу
Цөм ташуу
Хүмүүс
Хүмүүс
Энэ хүмүүс
Яаруу
Яаруу
Тун яаруу
Цэцэг
Цэцэг
Хумиаастай
Шүхэр
Шүхэр
Дэлгээстэй
Цув
Цув
Өмсөөстэй

Цонх
Цонх
Хөлрөөстэй
Өвс
Өвс
Дэрлээстэй
Өрх
Өрх
Дөндийлтэй
Хараа
Хараа
Тэрийг хараа!
Бороо
Бороо
Ширүүн бороо!



ХӨДӨӨ

Хөдөө би очоогүй
Хөдөө би үзээгүй
Хөрш айлын жаал л
Хөдөө очсон гэнэ
Хөдөө үзсэн гэнэ
Хөдөө үзсэн бүхнээ
Хөөр болгон ярилаа
Хөгтэй яриаг нь би
Бийр будгаар зурлаа
Таван хошуу мал нь
Таван давхар байшинд:

Доод давхарт
Том биетэйгээрээ
Тэмээ
Дээд давхарт
Тун адтайгаараа
Ямаа
Үлдсэн давхарт нь
Үхэр
Адуу
Хонь!






Таван малчин нь
 Таван давхар гэрт:
 Доод давхарт
 Тэмээ малладгаараа
 Тэмээчин
 Дээд давхарт
 Ямаа хариулдгаараа
 Ямаачин
 Үлдсэн давхарт нь


Үхэрчин
 Адуучин
 Хоньчин!
 Цаадах байшинд
 Цахилгаан дүүжин шатаар
 Наадах гэрт нь
 Нарийхан модон шатаар
 Өөд уруугаа
 Өгсөж бууна



Билчрийн
гэрлэн
дохиогоор
Бэлчээрт
сүрэг
гарна гэнэ
Улаан
ногоон
шар гэрэл
Урд нь
асч
унтарна гэнэ

Завиар үхэр хөвнэ
Замагт мөрөн гатална





Олсоор ямаа авирна
Оорцог хаднаа мацна

Тэмээ ботгоо үүрээд
Тэшин жонжин явна



Төрөх дөхсөн малыг
Түргэн тусламж зөөнө






Төрсөн жаахан төлийг
Түрдэг тэргэнд суулгана
Цэцэрлэгт хүрээлэнд хүргэж
Цэвэр агаарт гаргана.

Дүүжин дээр
хурга ишиг!



Пуужин дээр
унага тугал!

Төөрүүл дотор
ганц ботго!





Хараа муудсан мал
Хасах нэмэх шил зүүнэ




Хөл муудсан нэг нь
Хөнгөн модон таяг тулна




Хотынх шиг ханандаа
Хоёр мэнгэн цорготой
Нэг нь айрагных
Негеө нь сүүнийх!

Хөршийн наиз ингэж ярив
Хөгтэй яриа нь зураг болов
Хөдөө очих
Хөдөөг үзэх
Хүсэл минь нэг өдөр биелж
Хөдөө гарлаа
Хөдөөг харлаа

Талын айлууд холоос
 Таван давхар ажээ
 Манай хөршийн найз
 Магад үнэн хэлжээ
 Алсаас малын хашаа
 Арван давхар ажээ
 Айлын маань найз
 Аргагүй үнэн хэлжээ
 Ойртвоос
 Давхар давхар гэр нь
 Дан дан болчихлоо
 Талын зэрэглээнд
 Таван давхар болсон санжээ
 Манай хөршийн жаал
 Магад худал хэлсэн санжээ
 Очвоос
 Давхар давхар хашаа
 Дан дан болчихлоо
 Алсын зэрэглээнд
 Арван давхар болсон санжээ
 Айлын маань жаал
 Аргагүй худал хэлсэн санжээ



За тэгээд хөдөө чинь
 Замын гэрлэн дохио
 Завиар явдаг үхэр
 Олсоор авирдаг ямаа
 Шил зүүсэн мал
 Таяг тулсан мал
 Сүүний цорго
 Айрагны цорго
 Пуужин
 Дүүжин
 Түрдэг тэрэг
 Түргэн тусламж
 Амаржих газрын
 Аль нь ч алга
 Хөршийн найз маань
 Хөдөө гаряагүй юм санжээ
 Танил жаал маань
 Таагаад ярьсан юм санжээ
 Хөдөө аялаад ирэхдээ би
 Үзсэн харснаа зурсан даа
 Хөршийн найз минь түүнээс
 Үнэнийг мэдэж аваг даа







ХОТ


Манай хотыг үзээгүй
Малчны нэгэн жаалд
Хот ийм байдаг аа! гэж
Ярьж өглөө, би
Хот ийм байдаг уу? гэж
Зурж гарлаа, тэр!
Хотод
Бөөн хүнийг тээн гэлдэрсэн
Бөөр улаан унаа бий гэж
Намайг хэлэхэд
Найз жаал маань
Бөөн хүн бөхөнд нь овоорсон
Бөөр улаан тэмээ зурчихав





Хотод

Цөөн хүнийг тээн давхисан
Беөр алаг тэрэг бий гэж
Намайг хэлэхэд
Найз жаал маань
Цөөн хүн нуруунд нь сундалсан
Беөр эрээн морь зурчихав



Хотод

Алсаас харахад нүднээ тодхон
Арван давхар байшин бий гэж
Намайг хэлэхэд
Найз жаал маань
Айлын яндан шиг өндөр нарийн
Арван давхар амбаар зурчихав

Хотод
Хун шувуунаас дээгүүр нисдэг
Хурдан цагаан онгоц бий гэж
Намайг хэлэхэд
Найз жаал маань
Даль жигүүрээ дэлсэн шувуу шиг
Далавчaa дэвсэн онгоц зурчихав



Хотод
Халуун илчээрээ аргалаас илүү
Чулуун нүүрс түлдэг юм гэж
Намайг хэлэхэд
Найз жаал маань
Аргаар дүүрэн хар чулуу
Савраар түүсэн хүн зурчихав.

Хотод
Ачааны суудлын галт тэрэг
Арав хориороо холбоотой явдаг гэж
Намайг хэлэхэд
Найз жаал маань
Ачаатай хүнтэй модон тэргийг
Ар араас нь залгаатай зурчихав



Хотод
Зүс царай сайхан болгодог
Үс засах газар бий гэж
Намайг хэлэхэд
Найз жаал маань
Дэл гөхлий нь хайчилж зассан
Дэгжин хээр морь зурчихав



Хотод
Амьтан хүнд сүү түгээдэг
Алаг үнээ шиг тэрэг бий гэж
Намайг хэлэхэд
Найз жаал маань
Арвин сүүтэй алаг тэргийг
Сааж суугаа хүн зурчихав



Хотод

Хийгээр усаа шахан цацсан

Хиймэл бороотой тэрэг бий гэж

Намайг хэлэхэд

Найз жаал маань

Цацсан усны шүршээн дунд

Цахисан цахилгаан зурчихав



Манай хотод

Малчны жаалын зурсан

Беөр улаан тэмээ

Беөр эрээн адуу

Арван давхар амбаар

Дэрвэн дэвсэн онгоц

Үсчинд ордог морь

Үнээ шиг саадаг тэрэг

Цахилгаантай хиймэл бороо

Залгаастай модон тэрэг

Арагтай чулуун нүүрс

Аль аль нь алга даа!

Манай хотыг үзээгүй

Малчны тэр жаалд

Хот ийм байдаг гэж

Тод өнгөөр зурж өглөө

Хотын тухай

Дахин ярихаа больё доо

Тодын тод

Зураг минь өөрөө яриг даа!






ТАВАН ЗҮС

- Хурга хурга яагаад чи
Хундан цагаан болсон юм бэ?
- Цасны сүүлчээр төрсөн юм чинь
Цагаан болох нь аргагүй биз ээ
- Ишиг ишиг яагаад чи
Хадган цэнхэр болсон юм бэ?
- Цэлмэг өглөө төрсөн юм чинь
Цэнхэр болох нь аргагүй биз ээ
- Тугал тугал яагаад чи
Зосон улаан болсон юм бэ?
- Ургах нарнаар төрсөн юм чинь
Улаан болох нь аргагүй биз ээ
- Унага унага яагаад чи
Хилэн хар болсон юм бэ?
- Харанхуй шенө төрсөн юм чинь
Хар болох нь аргагүй биз ээ?
- Ботго ботго яагаад чи
Алтан шаргал болсон юм бэ?
- Шаргын.govд төрсөн юм чинь
Шар болох нь аргагүй биз ээ

ХОНИН СҮРЭГ

- Ах аа, энэ юу вэ?
- Аа, үсний сам уу?
- Биш, биш, биш!
- Би тэгвэл мэдэхгүй
- Сам биш хонь
Сайн ажигла даа
- Тийм үү?
Тэгвэл

Толгой тал нь хаанаа байна
Том сүүл нь хаанаа байна?
- Холоо бэлчиж яваа
Хонин сүрэг шүү дээ
Толгой тал нь
Том сүүл нь
Хаанаа байгаа нь
Харагдахгүй юм даа.



ТЭМЭЭНИЙ ЗУРАГ



Харандаа цаас нийлүүлж сурaad
Хамгийн түрүүнд тэмээ зураад
Ахдаа үзүүлтэл толгой сэгсэрч
Арай л биш байна гэлээ

Мэддэг хүнд үзүүл! гэлээ
Мэргэн үгийг нь сонс! гэлээ
Анхныхаа зургийг барьсаар
Айлынхаа хаалгыг татлаа


- Тэмээ нь тэмээ л юмсанж!
Тэгэхдээ л ондоо болсонж!
Ширээ бөх нь босоодож!
Ширнэн гуай ингэж зөвлөлөө

Баллаж зассаар байтал
Бараг бөхгүй болчихов оо.
Хараад байвал нэг л биш ээ
Хажуу айлдаа бас л орлоо

- Тэмээ нь тэмээ л юмсанж
Тэгэхдээ л ондоо болсонж!
Хүзүү нь арай өндөрдөж!
Хүрлээ гуай ингэж зөвлөлөө

Баллаж зассаар байтал
Бараг хүзүүгүй болчихов оо.
Сайн ажвал нэг л биш ээ
Саахалт айлдаа бас л очлоо

- Тэмээ нь тэмээ л юмсанж!
Тэгэхдээ л ондоо болсонж!
Нарийн хөл нь уртдаж!
Нацаг гуай ингэж зөвлөлөө



Баллаж зассаар байтал
Бараг хөлгүй болчихов оо.
Хөрш айлаар хэсэн хэссээр
Хүний үгээр засан зассаар

Атан тэмээгээ адаг сүүлд нь
Ахдаа үзүүлтэл мэл гайхаж:
- Хувирсаар хувирсаар тэмээ чинь
Хулгана болчихлоо гэж үү? гэлээ

Олон хүний зөвлөгөө хүчтэйг
Одоо л сайн мэдэж авлаа
Худал гэвэл atan тэмээг
Хулгана болгодог байна шүү.





ҮХЭР ТЭРЭГ

Үхэр тэрэг
Үг хэлнэ үү?
Дугуйт тэрэг
Дуу аялна үү?
Өгсүүр хэжлүүр
Өөдөөс тослоо
Өндөр даваа
Эгцэрч бослоо
Монгол шар
Хүчлэн зүтгэнэ
Модон тэрэг
Гаслан чихарна
- Тослоод өгөөч
Туслаад өгөөч
Тослоод өгөөч
Туслаад өгөөч!

Овооны доод руу
Өнгийн буулаа
Давааны цаад руу
Тонгойн орлоо
Амбан шар
Бөн бөн шогшино
Аралт тэрэг
Дэн дэн дэгдэнэ
Тостой ч яахав
Тосгүй ч яахав
Тустай ч яахав
Тусгүй ч яахав
Үхэр тэрэг
Үг хэлнэ ээ!
Дугуйт тэрэг
Дуу аялна аа!

CYY

Нар
Нар мандлаа л
Нуур
Нуур халлаа л
Үүр
Үүр дэгдлээ л
Үүл
Үүл үүслээ л
Бороо
Бороо орлоо л
Ногоо
Ногоо гарлаа л
Үнээ
Үнээ идлээ л
Эмээ
Эмээ саалаа л
Гал
Гал аслаа л
Сүү
Сүү хөөрлөө л
Өглөөний
Улаан нарнаас эхлээд
Эмээгийн
Цагаан сэтгэл хүртэл
Уудам орчлон шингэсэн хойно
Уухад амттай байлгүй яахав.



АЙРАГ


Эсс-сс-сэн айраг
Исс-сс-гэрэн шуугина.
Шш-ши-шинэхэн айраг
Шш-шш-шивнэн шуугина.



Хөхүүр дотроо
Хөөсс-сс-рэн шуугина.
Уусс-сс-ан дороо
Уруул чимчигнэнэ.

Айрагнаас
Ар хөндийн
Агь таана
Амтагдана

Аргагүй ч биз дээ, та минь
Адуу тэндээс ирсэн юм чинь!



ӨВДӨГЦӨӨ УС

Өндөр гээчийн хөх тэмээ
Гол гатлаад гарч явж
Өдөөс нь тэгтэл нэг ямаа
Зам дөтлөөд хүрч ирж.

- Гарч болох нь уу, үүгээр? гэж
Сэлмэн эвэрт майлан асууж
- Гайгүй, өвдөгцөө л юм байна! гэж
Ширээ бөхт буйлан хариулж

Үерлэсэн гол руу өнөө ямаа
Үгийн ч хариугүй шоволзоод орж
Эргэлдсэн усанд хөл алдаж
Эврийнх нь үзүүр цухалзаад ирж



Ам хамар нь ангалзах тоолноор
- Амь авар! гээд бархирч байж
Урт хүзүүгээ тэмээ сунгаад
Усны эрэгт татаж гаргаж

- Эвэр далдрам цүнхээл усыг
Өвдөгцөө гэж дэгсдүүлдэг
Эргүү тэнэг малуу, чи! гээд л
Сахалт ямаа омогдож гарч.

Атан тэмээ тоосон шинжгүй
Алсын бараа ширтэн зогсоно
Тэмээ гэдэг тэмээ л юм даа
Ямаа гэдэг ямаа л юм даа



БИЕЛГЭЭ



Би
Биелнэ

Бид
Биелнэ

Үүр цайхаас эхлээд
Үдэш болтол биелнэ
Үнээ саахаас эхлээд
Одод түгтэл биелнэ.
Урсгал мэнгэн горхины
Уянга эгшгээр биелнэ
Аясын цагаан салхины
Айзам эгшгээр биелнэ
Азай буурал биелнэ
Арьс элдэн биелнэ
Дэжээ эмээ биелнэ
Дээс томон биелнэ
Ард талд нь биелнэ
Айраг бүлэн биелнэ
Урд талд нь биелнэ
Утас ээрэн биелнэ
Суугаа хүн биелнэ
Сур нухан биелнэ
Босоо хүн биелнэ
Богц тохон биелнэ
Удамт малчин биелнэ
Уурга сунган биелнэ
Уран бусгүй биелнэ
Угалз шаглан биелнэ



Айлын үүдэнд биелнэ
Аарц шүүж л биелнэ
Аараг толгойд биелнэ
Аргал түүж л биелнэ
Хамт олноор биелнэ
Хашаа барьж биелнэ

Өнөр олноор биелнэ
Өвсөө хадаж биелнэ
Би
Биелнэ
Бид
Биелнэ



ТЭНГЭР

Газар би хэвтлээ
Газраас
Тэртээ-э-э-э дээр
Тэнгэр!
Арчсан толь шиг
Тэнгэрт
Аварга цагаан тэмээ
Буйлах ч үгүй
Туйлах ч үгүй
Явсаар
Явсаар
Ямаа болно.
Ямаа нь
Майлах ч үгүй
Цойлох ч үгүй

Хөвсөөр
Хөвсөөр
Тагтаа болно
Тагтаа нь
Таргалсаар
Таргалсаар
Заан болно
Заан нь
Задарсаар
Задарсаар
Загас болно
Загас нь
Бутарсаар
Бутарсаар
Алга болно



Тэнгэрт дахиад л
Хорсон
Хурсан
Хонин сүрэг
Тархан
Дөлхэн
Бэлчин гарлаа
Хонин сүрэг
Хүрлийсээр
Хүрлийсээр
Түмэн цэрэг болов
Түмэн цэрэг

Түрхэрсээр
Турхирсаар
Тэнгэрт дайн үүсгэв

Саарласан цэргүүд
Салхин жадаар чичлэнэ
Уурласан цэргүүд
Усан сумаар шүршинэ
Галан сэлэм гялсхийнэ
Гунан буу тасхийнэ
Дөлөн сэлэм зурсхийнэ
Дөнөн буу панхийнэ

Тэр л тулалдаан
Тэнгэрийн хаяа руу
Аажим аажмаар
Алслан одлоо
Гар бөмбөг
Ганц нэгхэн
Тэртээд нүргэлэн
Тэсрэх дуулдана.
Тулаан дуусч
Наран гийх нь
Ялалтын баяр!
Долоон өнгийн
Солонго татах нь
Ёслолын буудлага!



ОЙ

Ой ямар
Аймаар юм бэ?
Одоо би
Яамаар юм бэ?
Баруунаас зүүнээс
Барьж авах гээд ч
байгаа юм шиг
Урдаас хойноос
Урж тасдах гээд ч
байгаа юм шиг

Хамаг чадлаараа би
Хүүе! гэж хашгирлаа
Хариуд нь бас
Хүүе гэх сонсогдлоо.
Хөөвч ой амьтай юм байна.
Хүний хэл мэддэг юм байна
Шивнэн шивнэн ярьдаг
Шинэхэн наизтай боллоо.
Ойр дотно болсон хойно
Одоо юунаас аих билээ



ДАЙН

Дайн эхэллээ
Давшаад!
Дайчин цэргүүд
Дайраад!
Тачиг
Тачиг!
Тантар
Тантар!
Хангир
Чингэр!
Харжиг
Хуржиг!
Пян-н-н!
Пан-н-н!
Шип
Шуп
Пью
Пью!
Кхх
Кхх!
Тар-р-р!
Тар-р-р!
Пин-нн!
Пүн-нн!
Пирх-хх!
Пүрх-хх!





Манай цэргүүд
Урагшaa!
Дайсны цэргүүд
Ухраад!

- Манайх биш танайх дайсан!
- Маргаад яахав танайх дайсан!
- Яамай яамай танайх дайсан!
- Яршиг яршиг тэгвэл больё!

Дайсан хоёрын аль нь ч
Дайсан болохыг хүссэнгүй
Хоёулаа манай тал байж
Хоорондоо байлдалтай биш

Цаасан дээрхи дайн
Тэгсгээд дууслаа
Цаашаа хальж гараагүй нь
Яамай даа, яамай!



ТООНООР ШАГАЙСАН МУУР

Томоос том
Оготно зурлаа
Тооноор тэгтэл
Муур шагайлаа

Оготноо би
Эвхээд нуучихлаа
Отсон муур
Эргээд буучихлаа

Муур андуурахыг бодоход
Мундаг зурсан байгаа биз?



ГАР ТОМ

Гар
Гар
Гэрээс том
Гэр
Гэр
Гараас бага
- Яагаад?
- Яахав,
Гараа нүдэндээ ойртуулж
Гэрээ хараад үз л дээ!



Гар
Гар
Мориноос том
Морь
Морь
Гарнаас бага
- Яагаад?
- Яахав,
Гараа нүдэндээ ойртуулж
Морио хараад үз л дээ!

Гар
Гар
Нарнаас том
Нар
Нар
Гарнаас бага
- Яагаад?
- Яахав,
Гараа нүдэндээ ойртуулж
Нараа хараад үз л дээ!



ӨЛЗИЙХҮҮ



Өлзийхүү
Өдөр ч шөнө ч
Хоёр гараа алдлан
Хотны захад дэгийнэ.
Харанхуй бүрэнхий
Шөнө боллоо
Хашаатай хонь руу
Чоно гэтлээ
Өлзийхүү
Өмнөөс нь
Намуун салхинд
Найган бүжлээ
Сэвшээ салхинд
Сэргэн бүжлээ



Саарал чоно харуутаа
Санд мэнд зугатаалаа
Ай даа энэ
Азарган чоно
Аавын хуучин дээлнээс нь хүртэл
Айdag юм байна шүү дээ

САРАН ДЭЭРХИ ОХИН




Саран дээр юу байна?
Саатан ажваас
Савтай ус дамнасан
Сайн охин үзэгдэнэ
Тэргэл саран дээрх
Тэр л охин
Үдэш авсан усаа
Үүр цайтал зөөнө
Алсын саран дээрх
Ачит охин

Сарныхнаа ундах гэж
Савтай усаа тээнэ
Мэнгэн саранд хүрэхсэн
Мөрөндөө тээсэн
Хөнөөгтэй усыг нь авч
Хөөрхий охиныг амраахсан
Саран дээр юу байна?
Саатан ажваас
Савтай ус дамнасан
Сайн охин үзэгдэнэ


АЙЛЫН ЖААЛУУД ЯМАР ӨВГӨН ЭМГЭН БОЛОХ ТУХАЙ МИНИЙ БОДОЛ

Хүүхэд
Хүүхэд
Хөгшид болно
Хөвгүүд
Хөвгүүд
Өвгөд болно
Охид
Охид
Эмгэд болно



Баруун айлын
Баяраа хөвгүүн
Хусан шилбүүр унаад
Хурдалж гүйдэг өвгөн болно

Зүүн айлын
Зүргүй Ганаа
Балт сэлэм эргүүлээд
Байлдаж тоглодог өвгөн болно



Урд айлын
Урнаа охин
Бүдэрч ойchoод уйлдаг
Бүтэл муутай эмгэн болно



Хойт айлын
Хорлоо охин
Өнгийн чулуугаар гэр барьж
Өдөржин нааддаг эмгэн болно

Тэртээ айлын
Тэгшээ хөвгүүн
Чавхаар шувуу харвадаг
Цадиг муутай ёвген болно



Саахалт айлын
Сарнаа охин
Ээжийнхээ араар нуугддаг
Ичимхий нь дэндсэн эмгэн болно



Хүүхэд
Хүүхэд
Хөгшид болно
Хөвгүүд
Хөвгүүд
Өвгөд болно
Охид
Охид
Эмгэд болно

ЦЭНХЭР САЛХИ


Энхрий жаахан Сүнжий дүү минь
Эрээчиж эрээчиж орхисон
Эцэс төгсгөлгүй зураасаа
Эрчилсэн цэнхэр салхи гэлээ.

Анхныхаа том бүтээлийн тухай
Шүлэг бичиж өгөхийг хүслээ.
Аялгуу бадаг холбож суутал
Цэнхэр салхи сэвэлзэж гарлаа.

Шүлгийг минь тэгтэл нөгөө салхи
Шүүрч аваад хуйлран одлоо.
Хөх тэнгэрт миний шүлгийг
Хүргэж өгөх гэсэн юм болов уу?

АРВАН ЦЭЦЭГ

Нисэх онгоцноос
Нэг
Хоёр
Гурав
Гурав дээр дөрөв
Дөрөв дээр гурав
Нийлээд
Арван үр тэнгэрт цацлаа
Агаарт тэр хийсэн одлоо
Арван үрнээс
Нэг
Хоёр
Гурав
Дөрөв
Дөрөв дээр гурав
Гурав дээр гурав
Нийлээд
Арван цэцэг дэлбээ задаллаа
Алгуур алгуур дээрээс доошиллоо



Арван цэцэгнээс
Нэг
Хоёр
Гурав
Дөрөв
Тав
Тав дээр хоёр
Хоёр дээр гурав
Нийлээд
Арван зоригтон газарт буулаа
Агаарын цэцэгс дэлбээгээ хумилаа



ГУРВАН БААТАР

Баллуур

Баллуур
Баллуур
Балласаар
Балласаар
Байдаг бие нь
Багассаар
Багассаар
Алдааг минь
Арилгасаар
Арилгасаар
Зөрүүг минь
Зөвтгөсөөр
Зөвтгесөөр
Ээ!
Бүтэн биээ дуусгалаа
Бүхнээ надад зориуллаа
Байнга сурахад тусаллаа
Баатарлаг чамдаа баярлалаа



Харандаа

Харандаа
Харандаа
Хорогдоор
Хорогдоор
Хамаг бие нь
Барагсаар
Барагсаар
Үсэг тоонууд
Бичсээр
Бичсээр

Үзсэн харсныг минь

Зурсаар

Зурсаар

Ээ!

Нарийн биеэ дуусгалаа

Надад бүхнээ зориуллаа

Эрдэм сурхад тусаллаа

Эрэлхэг чамдаа баярлалаа



Саван

Саван

Саван

Илэгдсээр

Илэгдсээр

Сайхан бие нь

Элэгдсээр

Элэгдсээр

Халтар хултраас

Салгасаар

Салгасаар

Хамгаас хеөрхөн

Болгосоор

Болгосоор

Ээ!

Нандин биеэ дуусгалаа

Надад бүхнээ зориуллаа

Цэвэрч явахад тусаллаа

Чин зурхнээс баярлалаа



МАНГАС

Арван таван толгойтой атгаалжин хар мангасын тухай
эмээгийн ярьсан үлгэрийг сонсоод би их л бодолхийлэн
суурк ийнхүү зурлаа.



Хар балтай
Харандаа барилаа
Мангар биетэй
Мангас зурлаа
Мангас
Мангас
Ангас хийсэн амтай
Арван таван толгойтой
Мангас
Мангас
Зангас хийсэн хуруутай
Гучин хоёр гартай
Уршигт хар мангасыг
Ургын хуйваар чахалзуурдаад¹
Арван таван арзгар толгойд нь
Арван таван хазаар углаж
Арван таван цулбуур атгаж
Ганцаар би хөтлөн алхлав.
Гувжилсан² хар мангасыг
Гуриг³ яданги⁴ болгоод
Гучин хоёр хүнд гарти нь
Гучин хоёр хүрээ атгуулж
Гучин хоёр нүх малтуулж
Гучин хоёр мод суулгав





Аймсам⁵ хар мангасын
Айдар⁶ омгийг нь дараад
Арван таван том амаар нь
Арван таван нуур балгуулж
Арван таван өртөө алхуулж
Ангам говийг устай болгов.
Атгаалжин хар мангасаас
Айлтгүй шүү, найзууд aa!
Тохиож тулсан мангас биш
Толгойд орсон мангас шүү!
Дэргэд ирсэн мангас биш
Дэвтэрт зурсан мангас шүү!

Үгийн тайлбар

Мангасын дүрийг тодруулах зорилгоор эртний зарим үгийг хэрэглэв.

1. Чахалзуурдах – Уургын хуйваар чахалзуураар нь эрж хөдөлгөөнгүй болгох
2. Гувжлах – Нохой мэт хаздаг амьтны уяаны утг хийх темер
3. Гуриг – Тэнхээ тасрах
4. Яданги – Mash доройтох
5. Аймсам – Хилэгнэн зэвүүрхэм
6. Айдар – Догшин хэргийг байдал

ЭНЭТХЭГЭЭС ИРСЭН ЗАХИДАЛ



Анд монгол найзаа!
Амархан сайн байна уу?
Эрхэм монгол найз аа!
Энэтхэгээс бичиж сууна аа!
Танай тэнд
Танан цас
Ордог гэлцэнэ,
Үнэн үү?
Цавчим уулс
Цасан сари¹

Тохдог гэлцэнэ,
Үнэн үү?
Цалин мөнгөн
Цасан сумаар
Шидэлцдэг гэлцэнэ,
Тийм үү?
Цасан дээгүүр
Цанан хүлгээр
Давхилддаг гэлцэнэ,
Тийм үү?

1. Сари - Энэтхэг үндэсний ёмсгал

Хаа сайгүй
Хашийн цасан
Дардаг юм бол,
Найз аа!
Энд тэндгүй
Элбэг дэлбэг
Байдаг юм бол
Найз аа!
Хариу захидалд
Цасан ширхэг
Хийж явуулаач
За юу!
Халуун орны
Найз нартаа
Нээж үзүүлье
За юу!
Чин сэтгэлээс ёслов.
Чиний энэтхэг найз!




АРАНЗАЛ ЗЭЭРД

Аранзал зээрд мориороо
Алхуулан шогшууллаа
Шогшуулснаа хатирууллаа
Хатириулснаа ергүүллээ
Ергүүлснээ цогиуллаа
Цогиулснаа давхиуллаа
Талаар талаар
Ташуур өгөн
Ташуур өгөн
Довтолгов
Замаар замаар
Тоос босгон
Тоос босгон
Хурдалгав.
Хатан дэлхийг
Дөрвөн туурай
Дөрвөн туурай
Бөмбөрдөнө
Хайр чулуу
Арван зүгтээ
Арван зүгтээ
Цацагдана
Хөрст дэлхий
Хөлийн дор
Хөлийн дор
Жирэлзэнэ



Хөтөл гүвээ
Холын холд
Холын холд
Торолзоно
Сумын бараа
Тодорлоо
Тодорлоо
Сургуулийн байшин
Ойртлоо
Ойртлоо
Аранзал зээрд мориныхоо
Амыг татан цогиуллаа
Цогиулснаа ергүүллээ
Ергүүлснээ хатирууллаа
Хатириулснаа шогшууллаа
Шогшуулснаа алхууллаа





САЙН НАЙЗУУД

Сайн найзууд
Хөтлөлцөж явдаг
Салахгүй хамт
Олуулаа явдаг

Талын цэцэгс
Навч
навчаараа хөтлөлцөнө



Холын одод
Гэрэл
гэрлээрээ хөтлөлцнө

Харин бид
Гар
гараасаа хөтлөлцнө

Сайн найзууд
Хөтлөлцж явдаг
Салахгүй хамт
Олуулаа явдаг

ГАРЧИГ

Аав Эзж Би амгалан бол	47
алтан дэлхий амгалан	3
Аав	4
Эзж	6
Би	8
Өвөө	12
Эмзээ	14
Ах	16
Эгч	18
Дүү	20
Бороо	21
Хедөө	22
Хот	34
Таван зүс	40
Хонин сүрэг	41
Тэмзэний зураг	42
Үхэр тэрэг	45
Сүү	46
Айраг	48
Өвдөгцөө ус.	50
Биелгээ	52
Тэнгэр	55
Ой	56
Дайн	59
Тооноор шагайсан муур	60
Гар том	62
Өлзийхүү	63
Сааран дээрхи охин	64
Айлын жаалтууд ямар өвгэн	67
эмгэн болох тухай миний бодол	68
Цэнхэр салхи	70
Арван цэцэг	72
Гурван баатар	74
Мангас	76
Энэтхэгээс ирсэн захидал	76
Аранзал зээрд	78
Сайн найзууд	78



ААВ

"Аав" шүлгийн эх дүр нь миний аваардаагийн Жамба. Булган аймгийн Бүрэгхангай сумын харьяат. Монгол улсын хүндэт мэргэн харваач цолтой. Мал сүргээр гавихгүй ч сэтгэлзэр баян хүн байлаа. Газар усныхаа төлөө амиа тавьж явдаг хүн байсан учраас нутгийхая Ногоон морьт уулаар овоглох болсон. Ногоон морь ирээдүй цагийн хүлэг учираас их л билэгшээсэн дээ. Бид цөмөөрөө Ногоон мортынхон.



ЭЭЖ

"Ээж" шүлгийн эх дүр нь миний ээж Батын Сух. Бүрэгхангай сумын Шувуутын голд олон жил үнээс сааж, мал майлсан. Энэ номыг анх бүтээж байхад бид ээжийнхээ сүүн цагаан сэтгэлийг яаж зураахаа мэдэхгүй байсан. Одоо ч зурж чадаагүй л явна. Харин хоёр настай Сүнжий дүү минь салхийг зурж чадсан шуу. Энэ номыг бид гэр бүлээрээ бүтээсэн. Номын нэрнээс тодорхой байгаа биз дээ?



БИ

"Би" шүлгийн гол баатар нь миний дүү Жамбын Цолмонбаатар. Энэ номын зургийг 6, 7 насандaa зурсан. Ганбаа дүү харин туслах нь байв. Зураг дээр ч тэр нь мэдэгдэж байгаа биз дээ. Цолмон минь барилгын тэргүүлэх зэргийн инженер байлаа. Тэнгэрийн оронд тийм хүн хэрэгтэй болсон юм байлгүй дээ хеөрхий, орд харшаа барилхараар аваад явчихсан. Манай дэлхий олон олон аав, ээж, би-гээс бүрддэг. Тэд амгалан байвал дэлхийтамгалан.



Зохиогч